

АНУ, БНСУ, БНАСАУ-н харилцаа: Солонгосын хойгийн ойрын ирээдүй

Д.Отгонбаатар

2021.06.28

Ханойн дээд хэмжээний уулзалтаас хойш АНУ-БНАСАУ хоёр улсын харилцаа өнөөг хүртэл зогсонги байдалтай байна. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнд эрх барих болсон Ардчилсан намын засаг захиргаа Зүүн Азид явуулах гадаад бодлогодоо Ази дах уламжлалт холбоотон болох Япон, Солонгосын харилцаанд урьд өмнөөс илүү ач холбогдол өгч эхэлснээр Ерөнхийлөгч Д.Трампын өнгөрсөн 4 жилд баримталж ирсэн Америк эхэнд /America First/ бодлого¹ халаагаа өгч, шинэ засаг захиргаа олон улсад Америкийн эргэн ирэлт² /America is Back/ хийж буйг зарлаж, олон талт хамтын ажиллагаа /multilateralism/-ны бодлого³ баримтлахаа зарласан.

Ерөнхийлөгч Ж.Байдены засаг захиргааны танилцуулсан Умард Солонгосын талаарх гадаад бодлогод өмнөх ерөнхийлөгч нарын явуулж ирсэн Стратегийн хүлээлт /Strategic Patience/, Иж бүрэн тохироо⁴ /Big Deal/ бодлогоос ялгаатай тал нь дипломат яриа хэлэлцээнд суурилсан Нарийн тооцоолол бүхий бодит нөхцөл байдалд нийцүүлсэн бодлого⁵ /Calibrated and Practical Approach/-оо танилцуулсан билээ. /бодлогын харьцуулалтыг хүснэгтээс харах/. Мөн сүүлийн жилүүдэд АНУ-БНХАУ хоорондын худалдааны тэмцлээс улбаатай нэг талдаа АНУ, Япон, Солонгос, нөгөө талдаа БНХАУ, ОХУ, БНАСАУ бүс нутгийн орнуудын харилцаанд эрс дайсагнасан сөргөлдөөний шинж чанартай биш боловч харилцан талцсан, болгоомжилсон шинж чанар түлхүү ажиглагдаж эхэлсэн нь өнгөрөгч 4-р сард болсон АНУ-Японы дээд хэмжээний уулзалт, 5-р сард болсон АНУ-БНСУ-н төрийн тэргүүн нарын хийсэн хамтарсан мэдэгдлээс⁶ харж болно. Гэхдээ энэ шинж чанар нь Солонгосын хойгт урьд өмнө байгаагүй аюулгүй байдлын цоо шинэ нөхцөл байдал үүссэн гэсэн үг биш бөгөөд харин Солонгосын хойгт хандах Их гүрнүүдийн гадаад бодлогод зарим өөрчлөлт орсныг илтгэнэ. Ямархуу өөрчлөлт орж буйг өнгөрөгч 5-р сард болсон АНУ-БНСУ төрийн тэргүүн нарын хийсэн хамтарсан мэдэгдэл дээр тулгуурлан тоймлон өгүүлье.

АНУ-н Умард Солонгосын талаарх гадаад бодлого

2021 оны 4-р сарын 30-ны өдөр Цагаан ордны хэвлэлийн төлөөлөгч Жэн Псаки Умард Солонгосын талаар авч хэрэгжүүлэх гадаад бодлогоо боловсруулж дууссан тухай⁷

¹ Энэ нь Трамп ерөнхийлөгчийн үед баримталж ирсэн үндэсний эрх ашгийг тэргүүнд тавьсан бодлогыг үргэлжлүүлэхгүй гэсэн санаа биш болно.

² <https://edition.cnn.com/2021/04/28/world/biden-100-days-foreign-policy-intl/index.html>

³ <https://www.whitehouse.gov/wp-content/uploads/2021/03/NSC-1v2.pdf>

⁴ http://english.hani.co.kr/arti/english_edition/e_northkorea/900023.html

⁵ <https://www.whitehouse.gov/briefing-room/press-briefings/2021/05/20/background-press-call-by-a-senior-administration-official-on-the-official-working-visit-of-the-republic-of-korea/>

⁶ <https://www.whitehouse.gov/briefing-room/statements-releases/2021/05/21/u-s-rok-leaders-joint-statement/>

⁷ [Press Gaggle by Press Secretary Jen Psaki Aboard Air Force One En Route Philadelphia, PA | The White House](https://www.whitehouse.gov/press-gaggle/2021/06/28/press-gaggle-by-press-secretary-jen-psaki-aboard-air-force-one-en-route-philadelphia-pa)

олон нийтэд мэдэгдсэн. Ерөнхийлөгч Д.Трампын Иж бүрэн тохироо /Grand Bargain/, Ерөнхийлөгч Б.Обамагийн Стратегийн хүлээлт /Strategic Patience/ бодлогын холимог дундын хэлбэр буюу нарийн тооцоолол бүхий бодит нөхцөл байдалд нийцүүлсэн бодлого өмнөх ерөнхийлөгч нарын бодлогоос ялгаатай нь тухайн нөхцөл байдалд уялдуулан авах засварлаж, шат дараатай авах арга хэмжээ гэжээ. Өөрөөр хэлбэл Обамагийн захиргааны Стратегийн хүлээлт бодлого шиг “Умард Солонгосын талаар идэвхтэй бодлого явуулахгүй, Умард Солонгосын зүгээс эхлээд нааштай хариу өгтөл хүлээх бөгөөд Трамп ерөнхийлөгчийн засаг захиргааны явуулсан Дээрээс доошоо /Top-down/ бодлого⁸ шиг иж бүрнээр асуудлыг нэг дор бүрэн шийдвэрлэх гэж оролдохгүй, харин ажлын хэсгийн түвшний тодорхой үр дүнтэй, яриа хэлэлцээний замаар асуудлыг шийдвэрлэх, Умард Солонгосыг бүрэн цөмийн зэвсэггүй болтол эдийн засгийн хориг тавих бодлогоо үргэлжлүүлэх⁹ зэрэг багтана гэж мэдэгдсэн.

Ерөнхийлөгч Ж.Байден тангараг өргөж ажилдаа орсноос хойш 100 дахь хоног дээрээ “Иран болон Умард Солонгосын цөмийн асуудал АНУ болоод олон улсын аюулгүй байдалд заналхийлэл учруулж байгаа тул холбоотны улсуудтай хамтран дипломат яриа хэлэлцээ болон тогтоон барих/deterrence/бодлогоор дамжуулан хариу үзүүлэх болно¹⁰ гэж мэдэгдэв.

АНУ-н зүгээс Умард Солонгосын талаар авч хэрэгжүүлэх гадаад бодлогоо танилцуулснаас хойш 2 хоногийн дараа буюу 5-р сарын 2-ны өдөр БНАСАУ-н ГХЯ-ны Хойд Америкийн газрын дарга Гвон Жон Гын мэдэгдэл¹¹ гаргаж “Умард Солонгосын цөмийн зэвсгийн хөгжүүлэлт АНУ-ын аюулгүй байдалд ноцтой заналхийлэл /serious threat/ учруулж байна хэмээн мэдэгдэж Байден ерөнхийлөгчийн Сенатад танилцуулсан 4-р сарын 30-ны өдрийн Умард Солонгосын талаар авч хэрэгжүүлэх бодлогод сэтгэл дундуур байгаагаа илэрхийлсэн нь Умард Солонгосын зүгээс өөр өндөр хүлээлттэй байсны илрэл. Энэ мэдэгдэл бол АНУ-н засгийн газрын гадаад бодлогын талаарх Умард Солонгосын анхны албан ёсны мэдэгдэл байсан.

Хүснэгт-1 АНУ-н Ерөнхийлөгч нарын Умард Солонгосын талаар хэрэгжүүлж ирсэн гадаад бодлогын харьцуулалт

	Обама ерөнхийлөгчийн бодлого	Трамп ерөнхийлөгчийн бодлого	Байден ерөнхийлөгчийн бодлого
Бодлого	Стратегийн хүлээлт	Том хэлцэл /лууван ба ташуурын аргыг хослуулах/	Бодит нөхцөлд нийцүүлэн хандах,
Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй бүс болгох	Умард Солонгосыг өөрсдөөр нь эхэлж цөмийн зэвсгээс татгалзуулах	Өөрсдөө аль эсвэл шахалтаар цөмийн зэвсэггүй болгох	Магадлал бага боловч Өөрчлөлтийг өдөөх замаар

⁸ http://english.hani.co.kr/arti/english_edition/e_northkorea/900023.html

⁹ The complete denuclearization of the Peninsula, phased agreement, practical progress, practical approach

¹⁰ <https://www.bbc.com/news/world-asia-56960008>

¹¹

<http://www.kcna.kp/kcna.user.article.retrieveNewsViewInfoList.kcmsf.jsessionid=6163A8EDA75E50F1DA49B878D1D69308#this>

	/магадлал бага/		
Боломжит хувилбарууд	Ганцаардуулах, шахалт үзүүлэх	Дипломат яриа хэлэлцээ, цэргийн шахалт үзүүлэх хувилбар	Цэвэр дипломат яриа хэлэлцээгээр дамжуулах
Аюулгүй байдлын баталгаа гаргах талаар	Тодорхой тусгаагүй	Иж бүрнээр тохирох, /цөмийн зэвсэггүй болох газрын зураг/ Эргэн хянах механизм	Үе шат дараатай арга хэмжээ авах,
АНУ-БНАСАУ-н харилцааг сайжруулах чиглэлээр	Умард Солонгос эрс шийдвэр гаргахгүй бол боломжгүй	Хоёр улсын төрийн тэргүүн нарын хувийн харилцааг чухалчилсан	Цөмийн зэвсэггүй болох процесстой уялдуулан хандах

Түүнчлэн, Дэлхийд эдийн засгаараа тэргүүлэгч Их Долоогийн бүлэг 6-р сарын 11-13 өдрүүдэд Английн Корнволл дахь далайн эргийн Карбис бэй тосгонд чуулав. Дэлхий нийтээр тархаад буй цар тахлаас хойш анх удаа нүүр тулан уулзаж буй энэхүү дээд хэмжээний уулзалтад БНСУ, ӨАБНУ, Австралийн төрийн тэргүүнүүд оролцож гаргасан хамтарсан мэдэгдэлдээ¹² “Бид Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангижруулах, НҮБ-ын аюулгүй зөвлөлийн тогтоолыг үндэслэн хууль бус үй олноор хөнөөх зэвсэг, цөмийн хөтөлбөрөөс хөндлөнгийн хяналтан дор бүрэн татгалзахыг уриалж байна” гэв.

Сүүлийн үед барууны хэвлэлээр Умард Солонгосын удирдагчийн эрүүл мэндийн асуудал анхаарлын төвд байна. Солонгосын хойгоор мэргэшсэн Энкэй нюс мэдээлэхдээ “Умард Солонгосын удирдагч 1 сар гаруй хугацаанд олны өмнө ил гараагүй нь түүний эрүүл мэндтэй холбоотой болох” тухай мэдээлжээ.

АНУ, БНСУ-ын Төрийн тэргүүнүүдийн хийсэн хамтарсан мэдэгдэл

Сүүлийн хэдэн жил АНУ-БНСУ хоёр орны дээд түвшний харилцааны давтамж өсөж, нийгэм эдийн засаг худалдаа болон бусад салбарт идэвхтэй хөгжиж байна. АНУ-н ерөнхийлөгч Ж. Байден, БНСУ-ын Ерөнхийлөгч Мүн Жэ Ин нар 5-р сарын сүүлээр Вашингтон хотод уулзаж хоёр орны харилцаа, олон улсын болон бүс нутгийн бусад асуудлаар шууд яриа хэлэлцээ явуулж, харилцан ойлголцлоо гүнзгийрүүлж, АНУ-БНСУ харилцааг цаашид хөгжүүлэх талаар хэлэлцэв. Хоёр улсын тэргүүнүүд Солонгосын хойгийн цөмийн асуудал, Мьянмар улсад бий болоод буй нөхцөл байдал, уур амьсгалын өөрчлөлт, дэлхий нийтээр тархаад буй цар тахалтай хамтан тэмцэх, олон улсын эрүүл мэндийн хамтын ажиллагааны механизмыг бий болгох, 5G технологи, хиймэл оюун ухаан, сансар судлалыг хөгжүүлэх гэх мэт олон асуудлын талаар санал солилцож хамтарсан мэдэгдэлдээ¹³ гаргав.

Хамтарсан мэдэгдэлд хоёр улсын тэргүүнүүд АНУ-БНСУ хоорондын холбоотны харилцааг хөгжүүлэх тууштай хүсэл эрмэлзэлтэй байгааг нотолж, хүний эрх, хууль дээдлэх,

¹² <https://www.whitehouse.gov/briefing-room/statements-releases/2021/06/13/carbis-bay-g7-summit-communicue/> 58-р заалтыг үзэх,

¹³ <https://www.whitehouse.gov/briefing-room/statements-releases/2021/05/21/u-s-rok-leaders-joint-statement/>

үнэт зүйлээ хуваалцдаг шинэ эрин цаг үеийн өөрчлөлт шаардлагад нийцсэн харилцааг хөгжүүлэх чиглэлээр санал нэгтэй байгаагаа илэрхийлэв.

Үүнд: хоёр улсын тэргүүнүүд Умард Солонгостой дипломат яриа хэлэлцээний замаар Солонгосын хойгийг бүрэн цөмийн зэвсэггүйжүүлэх үйл явц болоод энх тайван тогтоох шаардлагатай гэдэг дээр санал нийлэв.

- Ерөнхийлөгч Ж.Байден хамтарсан хэвлэлийн хурлын үеэр АНУ-д хөрөнгө оруулалт хийхээр болсон БНСУ-ын томоохон аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлд талархал илэрхийлсэн. Уг айлчлалын үеэр БНСУ-ын Самсунг, Хюндай, Эс Кэй (SK), Эл Жи (LG) зэрэг томоохон группүүд АНУ-д 40 тэрбум долларын¹⁴ хөрөнгө оруулалтыг хагас дамжуулагч, цахилгаан машин, зай хураагуур /battery/ салбарт оруулахаар зарласан нь энэ удаагийн уулзалтын нэг онцлох зүйл байв.
- Технологийн хөгжил, дэлхий нийтээр тархаад буй цар тахалтай тэмцэх, уур амьсгалын өөрчлөлт, цэвэр эрчим хүч зэрэг зэрэг салбаруудад хамтран ажиллах хэрэгжүүлэх төлөвлөгөөг агуулсан Хамтын ажиллагааны баримт бичиг¹⁵/Fact sheet: United States-Republic of Korea Partnership/-ийг Хамтарсан мэдэгдлийн дагалдах төлөвлөгөө болгон танилцуулсан.
- Мөн түүнчлэн Хамтарсан мэдэгдэлд “Өмнөд Хятадын тэнгис дэх олон улсын дэг журмыг хүндэтгэн үзэх, “Тайваний/Taiwan/ энх тайван аюулгүй байдлыг хадгалах ач холбогдолыг онцлох” гэсэн заалт орсон нь дээр дурдсан Хятадыг тогтоон барих АНУ-н бодлогыг тодорхой хэмжээнд дэмжихээ илэрхийлсэн нь¹⁶ нь судлаачдын анхаарлыг ихээхэн татаж байлаа. Хамтарсан мэдэгдлийн дараа Сөүл дэх БНХАУ-ын Элчин сайд Шин Хай Мин (өмнө Монгол Улсад элчин сайдаар сууж байсан) хэвлэлд ярилцлага өгч “Хятад гэж нэр заагаагүй боловч Хятадын үндэсний эрх ашгийг хөндөх аваас бид зүгээр суух боломжгүй” гэсэн утга бүхий ярилцлага¹⁷ өгч мөн л энэхүү хамтарсан мэдэгдэлд сэтгэл дундуур байгаагаа илэрхийлсэн.
- Мөн энэ уулзалтын үеэр Квад/Quad/-н¹⁸ хамтын ажиллагааны механизмд БНСУ-г элсүүлэх эсэх тухай ярилцана гэсэн судлаачдын таамаглал өндөр байсан ч энэ удаа яригдаагүй байна. Энэ асуудал мөн л Солонгосын хойгийн нөхцөл байдалд хамааралтай, ялангуяа БНСУ-Хятад улсын харилцаанд нөлөөлөх чухал асуудал тул БНСУ ямар шийдвэр гаргах нь судлаачдын сонирхолыг ихээхэн татаж байсан.

¹⁴ http://world.kbs.co.kr/service/contents_view.htm?lang=e&board_seq=403678

¹⁵ <https://www.whitehouse.gov/briefing-room/statements-releases/2021/05/21/fact-sheet-united-states-republic-of-korea-partnership/>

¹⁶ https://news.sbs.co.kr/news/endPage.do?news_id=N1006329144&plink=ORI&cooper=DAUM

¹⁷ https://news.sbs.co.kr/news/endPage.do?news_id=N1006329144&plink=ORI&cooper=DAUM

¹⁸ АНУ, Япон, Австрали, Энэтхэн улсын хамтарсан аюулгүй байдлын механизм, Энэхүү механизмийг анх Япон улсын Абе ерөнхий сайд 2007 онд анх санаачилж байжээ. Kevin Rudd. The Prime Minister Years, page. 47, 2018, Macmillan.

Солонгосын хойгийн талаар:

- 2018 оны Панмунжомын тунхаг¹⁹, АНУ-БНАСАУ-ын Сингапурын хамтарсан мэдэгдэл²⁰ зэрэг өмнөх бодлого, хамтын тохироо дээр суурилсан гадаад бодлого, яриа хэлэлцээр Солонгосын хойгийг цөмийн зэвсэггүй бүс болгоход зайлшгүй чухал гэдэг дээр нэг байр суурьтай байгаагаа талууд нотлов.
- Ерөнхийлөгч Ж.Байден Өмнөд болон Хойд Солонгосын хоорондын аливаа яриа уулзалт, хэлэлцээр явуулахыг дэмжиж байгаагаа илэрхийлж, хоёр тал Умард Солонгосын хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хоёр талд салсан гэр бүлүүдийг уулзуулах зэрэг дээр хамтран ажиллахаар тохиролцсав.
- Хамтарсан хэвлэлийн хурлын үеэр Ерөнхийлөгч Ж.Байден ерөнхийлөгч Умард Солонгосын асуудлаар мэргэшсэн Сон Ким²¹ Төрийн департаментын Туслах нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгчийг Умард Солонгосын асуудал хариуцсан тусгай элч (U.S. Special Envoy for the DPRK)-ээр томилсон. Туслах нарийн бичгийн дарга Сон Кимийн хувьд Ерөнхийлөгч Обамагийн засаг захиргааны үеэс эхлэн өнөөг хүртэл Умард Солонгосын асуудлыг хариуцаж ирсэн бөгөөд Сөүл болон Манилад элчин сайдаар ажиллаж байжээ.
- Хамтарсан мэдэгдэлд “тодорхой нөхцөл байдалд тулгуурласан хамтарсан командлалын эрхийг шилжүүлэх” талаар тууштай байгаагаа хоёр тал нотолсноос гадна АНУ-БНСУ хамтын “Баллистик пуужингийн удирдамж”²² баримт бичгийг дуусгавар болгосноор БНСУ цаашдаа 800 км дээш тусгалтай пуужин хөгжүүлэх боломжтой болсон нь энэхүү дээд хэмжээний айлчлалын нэг том үр дүн боллоо гэж тоймчид үзэж байна. БНСУ 800 км дээш тусгалтай пуужин хөгжүүлэх боломж нээгдснээр цаашид энэ асуудлаар БНХАУ, БНАСАУ, Япон зэрэг улс ямар байр суурьтай байх нь одоогоор тодорхойгүй байгаа ч энэ бол Өмнөд Солонгосын хувьд ихээхэн ач холбогдолтой.

БНАСАУ-н гадаад бодлого, байр суурь

2021 он гараад БНАСАУ-ын Хөдөлмөрийн намын 8-р их хурал хуралдаж ирэх 5 жилийн эдийн засгийн төлөвлөгөө, гадаад бодлогын чиг шугамаа тодорхойлсон. 2020 онд дэлхий нийтээр тархаад буй цар тахал, 3 удаагийн хар салхи, байгалийн их хэмжээний үер,

¹⁹ https://en.wikipedia.org/wiki/Panmunjom_Declaration

²⁰ <https://th.usembassy.gov/joint-statement-president-donald-j-trump-united-states-america-chairman-kim-jong-un-democratic-peoples-republic-korea-singapore-summit/>

²¹ <https://www.reuters.com/world/asia-pacific/new-us-envoy-north-korea-huddle-with-skoreans-japanese-2021-06-20/>

²² <https://thediomat.com/2021/06/could-more-powerful-south-korean-ballistic-missiles-actually-help-north-korea/>

эдийн засгийн хориг зэрэг томоохон сорилттой жил байсан бөгөөд 8-р хурлаар гадаад бодлогын ямархуу чиг шугам баримтлах нь ихээхэн сонирхол татаж байсан боловч тодорхой шийдвэр танилцуулаагүй. Учир нь цаг хугацааны хувьд АНУ-ын шинэ ерөнхийлөгч тангарагаа өргөхөөс өмнө 8-р хурал хуралдсан, хоёрдугаарт АНУ-аас Умард Солонгосын талаар авч хэрэгжүүлэх гадаад бодлого тодорхой болоогүй байсантай холбож үзэж болно. 2-р сараас АНУ-ын шинэ засаг захиргаа олон сувгаар Умард Солонгостой холбоо тогтоох гэж оролдож ирснийг Умард Солонгосын Гадаад хэргийн дэд сайд Чой Сон Хи 3-р сард хийсэн мэдэгдэлдээ онцолж байсан бөгөөд цаг хожих гэсэн АНУ-ын талтай дахин ширээний ард суухгүй тэр бүү хэл Сингапур, Ханойн уулзалт шиг дахин тийм уулзалт хийхгүй гэж мэдэгдэж байсан. Хэдийгээр Умард Солонгосын хувьд өнгөрсөн жил ихээхэн сорилтын жил байсан боловч цөмийн зэвсгийн хөтөлбөрөө үргэлжлүүлсээр ирэв. АНУ-ын Рэнд судалгааны корпорацийн тайланд Умард Солонгос 2027 он гэхэд 242 цөмийн зэвсэгтэй болно²³, мөн Стокхолмын олон улс судлалын хүрээлэнгээс гаргасан 2020 оны тайланд²⁴ өнгөрсөн жилд цөмийн хөтөлбөрөө өргөжүүлсэн тухай дурдсан нь цаашдын Солонгосын хойгийн нөхцөл байдлыг эерэгжүүлэхэд дам болон дам бус байдлаар нөлөөлөх нь дамжиггүй.

БНАСАУ-ын удирдагч Ким Жөн Ун 2021 оны 6-р сарын 16-19 өдрүүдэд Хөдөлмөрийн намын Төв хорооны 3-р бүгд хурлыг хуралдуулж, 8-р их хурлын шийдвэрийн биелэлтийн байдалтай танилцсан. Мөн энэ хурлын 3 дах өдөр АНУ-ын талаар баримтлах гадаад бодлогын стратеги, чиглэлийг тодорхойлж, АНУ-тай яриа хэлэлцээр хийх, дайсагнах аль аль нөхцөл байдалд бэлэн байх²⁵ тухай онцлон тэмдэглэсэн. АНУ-ын Засаг захиргааны Солонгосын хойгийн асуудал эрхэлсэн тусгай элчийн Сөүлд хийх албан томилолтоос²⁶ хоёр хоногийн өмнө ийнхүү албан байр сууриа илэрхийлсэн нь яриа хэлэлцээрийн ширээнд эргэн ирэх сонирхолтой байгаагаар тойруу замаар илэрхийлж буй хэрэг хэмээн Солонгосын хойг судлаачид үзэж байна. Ер нь Умард Солонгосчууд хэзээ, хэнээр ямар мэдэгдэл хийлгэхийг нарийн тооцоолдог бөгөөд 3-р сард АНУ-н Төрийн нарийн бичгийн дарга Т.Блинкен, Батлан хамгаалахын сайд Л.Аустин нарыг Сөүлд айлчлахын урд өдөр мэдэгдэл гаргаж байсан бол 4-р сарын 30-нд Цагаан ордноос Умард Солонгосын талаарх авч хэрэгжүүлэх гадаад бодлогоо танилцуулсны дараа 3 давхар²⁷ мэдэгдэл гаргаж АНУ-ын засаг захиргааг буруушааж байсан²⁸ юм. Өмнөх хурлуудын үеэр АНУ-ыг буруушаасан, эрс шүүмжилсэн мэдэгдлийг гаргаж байсан бол энэ удаагийн хурлаар хатуу шүүмжилсэн мэдэгдэлээс зайлсхийсэн нь яриа, хэлэлцээрийн ширээнд эргэн ирнэ гэсэн Солонгосын хойг судлаачдын таамаглалыг бодитой байх гэж үзэхэд хүргэж байна. АНУ-ын зүгээс ч 3-р

²³ <https://www.rand.org/pubs/perspectives/PEA1015-1.html>

²⁴ <https://www.sipri.org/media/press-release/2021/global-nuclear-arsenals-grow-states-continue-modernize-new-sipri-yearbook-out-now>

²⁵ http://www.rodong.rep.kp/en/index.php?strPageID=SF01_02_01&newsID=2021-06-19-0004

²⁶ <https://www.state.gov/travel-of-special-representative-for-the-democratic-peoples-republic-of-korea-sung-kim-to-seoul/>

²⁷ БНАСАУ-н Гадаад хэргийн яам, Гадаад хэргийн яамны Хойд Америкийн газрын дарга, Хөдөлмөрийн намын Төв хорооны хэлтсийн орлогч дарга Ким Ё Жон нарын 3 мэдэгдэл нэгэн зэрэг гарсан.

<http://www.rodong.rep.kp/ko/>

²⁸ <http://www.rodong.rep.kp/en/>

Бүгд хурлын шийдвэрийг нааштай хүлээн авч хэзээ ч хаана ч урьдач нөхцөлгүйгээр уулзахад бэлэн байна²⁹ гэж Сон Ким тусгай элч мэдэгдэв.

Цар тахлын улмаас Умард Солонгосууд хилээ хааснаар БНХАУ, ОХУ харилцаа, гадаад худалдаа удааширч байсан бол 2021 он гараад сэргэх төлөв ажиглагдаж байна. БНХАУ-н дарга Си Жинь Пин Умард Солонгост айлчилсны 3 жилийн ойн арга хэмжээг хоёр талд өргөн тэмдэглэж өнгөрүүлсэн. Удахгүй 7-р сард ХКН/Хятадын коммунист нам/-н 100 жилийн ойн баярын арга хэмжээнд Умард Солонгосын төрийн өндөр албан тушаалтан айлчлах нь тодорхой бөгөөд Ким Жөн Ун айлчлах уу, Хөдөлмөрийн намын удирдлагуудаас өөр хүн оролцох эсэх нь одоогоор тодорхойгүй байна. БНАСАУ энэ оны 1-р сард Бээжинд суух элчин сайдаар Шадар сайд бөгөөд Гадаад худалдааны сайдаар олон жил ажилласан Ри Юн Намыг элчин сайдаар³⁰ томилсон нь Хятад улстай хийх харилцаан дээр ялангуяа гадаад худалдаагаар мэргэшсэн хүн томилдог нь эдийн засгийн асуудалдаа ямар их ач холбогдол өгч байгаагийн нэг илрэл болно.

Өөр нэг онцлох зүйл бол Хятад улс хоёр жил томилоогүй эзэнгүй байсан Солонгосын хойгийн асуудлыг хариуцсан тусгай үүрэг гүйцэтгэгчээр элчин сайд Лю Сяоминийг томилсон явдал нь Хятад улс Солонгосын хойгын асуудалд анхаарал хандуулахын нэг илрэл гэж үзэж үндэслэл байгаа нь элчин сайд Лю Сяомин ажилдаа томилогдсноос хойш ОХУ-н Гадаад хэргийн дэд сайд Игор Моргулов³¹, ОХУ-аас БНХАУ-д суух элчин сайд Андрэй Дэнисов³², БНСУ-н Солонгосын хойгийн асуудлыг хариуцсан тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд Ну Гю Дог³³, мөн Англи улсаас Хятад улсад суух элчин сайд Каролин Вилсон³⁴ нартай Солонгосын хойгийн асуудлаар санал солилцож ярилцсан байна.

Дүгнэлт

Ж.Байден ерөнхийлөгчийн захиргаа Умард Солонгосын хойгийн талаарх авч хэрэгжүүлэх гадаад бодлогоо танилцуулахын зэрэгцээ 2-р сараас хойш Умард Солонгостой янз бүрийн шугамаар холбоо тогтоох оролдлого хийж ирсэн боловч Умард Солонгосын зүгээс ямар нэг дорвитой хариуг одоогоор өгөөгүй байна. Өмнөд Солонгосын хувьд Мүн Жэ Ин ерөнхийлөгч ирэх жил ерөнхийлөгчийн албыг хүлээлгэж өгөх хүртлээ Умард Солонгостой харилцаагаа сэргээх, Солонгосын хойгт энх тайвны үйл явцыг эхлүүлэх чиглэлээр хичээл зүтгэл гаргаж ажиллах болно³⁵ гэж мэдэгдсэн. Мүн Жэ Ин ерөнхийлөгч 2017 оноос хойш АНУ-БНАСАУ харилцааг сэргээхэд ихээхэн хүчин зүтгэл гаргаж Сингапур, Ханойн уулзалт болоход зуучлагчийн үүргийг амжилттай биелүүлсэн гэж үздэг ч нөгөө талаар хангалттай бодит үр дүн гаргаж чадаагүй гэж судлаачид дүгнэдэг. АНУ-БНСУ-н төрийн тэргүүн нарын уулзалтын үр дүнд БНСУ 800 км дээш дундын болон алсын тусгалтай пуужин хөгжүүлэх боломжтой болсон нь цаашид хоёр Солонгосын харилцаанд хэрхэн

²⁹ https://www.nknews.org/2021/06/sung-kim-us-willing-to-meet-north-korea-anytime-anywhere/?utm_source=dlvr.it&utm_medium=twitter

³⁰ https://www.fmprc.gov.cn/mfa_eng/zxxx_662805/t1879305.shtml

³¹ https://www.fmprc.gov.cn/mfa_eng/wjdt_665385/wshd_665389/t1882050.shtml

³² https://www.fmprc.gov.cn/mfa_eng/wjdt_665385/wshd_665389/t1883969.shtml

³³ https://www.fmprc.gov.cn/mfa_eng/wjdt_665385/wshd_665389/t1886153.shtml

³⁴ http://world.kbs.co.kr/service/news_view.htm?lang=e&Seq_Code=162279

³⁵ <https://time.com/6075235/moon-jae-in-south-korea-election/>

нөлөөлөх вэ гэдэг асуулт урган гарч ирэх бөгөөд цаашлаад хойгийг тойрсон асуудалд нөлөөлөх эсэх нь асуултын тэмдэг хэвээр үлдэж байна.

Умард Солонгосын Хөдөлмөрийн намын Төв хорооны 3-р хурлаар АНУ-ын талаар баримтлах гадаад бодлогын стратеги, чиглэлээ тодорхойлж яриа хэлэлцээр хийхэд бэлэн, нээлттэй байгаа тухай удаа дараа онцолж байгаа боловч Умард Солонгос хэзээ яриа хэлэлцээрийн ширээнд суух нь тодорхойгүй байгаа бөгөөд нэг зүйл тодорхой байгаа нь Хөдөлмөрийн намын 8-р их хурлаар батлан хамгаалах салбар, стратегийн зэр зэвсгээ сайжруулах талаар шийдвэр гаргаж алсын зайн тусгалтай, тив алгасах/ICBM/ пуужин хөгжүүлэлт үргэлжлүүлэн хийж байгаа нь энэ бүс нутгийн асуудалд илүү анхаарал хандуулж байх хэрэгтэйг олон улсын хүрээлэнгүүд онцолж байна.

Эцэст нь БНХАУ 2 жилийн хугацаанд томилгоо хийгдээгүй байсан тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайдын албан тушаалд өмнө нь Англи болон Умард Солонгост сууж байсан элчин сайд Лю Сяоминг томилсон бол АНУ Обамгийн засгийн газрын үеэс Умард Солонгосын асуудал хариуцаж ирсэн туршлагатай мэргэжилтэн Сон Кимийг томилж, тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд нар ажилдаа орсон нь энэ оны сүүлийн хагаст Солонгосын хойгийг тойрсон асуудлаар тодорхой шийдэлд хүрдэггүй юм гэхэд Умард Солонгос АНУ болон Өмнөд Солонгостой яриа хэлэлцээрийн ширээнд сууж болох юм. Яагаад гэвэл 2 жил үргэлжилсэн цар тахал, байгалийн гамшгаас улбаалсан хүнсний хомсдол, эдийн засгийн хориг зэрэг нь Умард Солонгосын эдийн засагт ихээхэн хүнд сорилт болж буй бөгөөд энэ хүнд сорилтыг даван туулахын тулд Хятад, ОХУ улстай найрамдалт түүхэн харилцаагаа өргөжүүлэн үргэлжлүүлэх, АНУ-ын шинэ засаг захиргаатай хэлэлцээрийн ширээнд сууж байж шийдвэрлэх шаардлагатай. Мөн хоёр Солонгосын харилцаа ч энэ хүнд сорилтыг даван туулахад чухал ач холбогдолтой.